

# БНСУ-д ЗОРЧИХ ВИЗ МЭДҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

2011-12-15

БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яам

# Г а р ч и г

## 1. Богино хугацааны нийтлэг (С-3-1) статус

- А. Хурал семинар, төрөл бүрийн арга хэмжээнд оролцогч болон нөхөрсөг тэмцээн уралдаанд оролцогч -----4
- В. Сургалт, дадлага -----5
- С. Төрөл садныдаа зочлох (БНСУ-ын иргэн, F-2, F-5, F-6 ангиллын визтэй оршин суугч урих)-----6
- Д. Төрөл садныдаа зочлох (бусад төрлийн ангиллаар урт хугацаагаар оршин суугч урих) -----7
- Е. Монгол улсад оршин суугаа Солонгос иргэний гэр бүлийн хүн (түүний ойрын төрөл садан) Солонгост зочлох -----8
- F. Солонгосын хөрөнгө оруулалттай компаний ажилтан (Солонгос захирлын хамт) Солонгост зочлох -----9

## 2. Аялал жуулчлал (С-3-2)

- А. Хувиараа аялах/ хилээр нэвтрэх -----10
- В. Группээр аялах / аялал жуулчлалын компаниар дамжин аялах -----11

## 3. Эмчилгээ аялал (С-3-3)

- А. Гадаадын өвчтөн хүлээн авах байгууллага (Эмнэлгийн болон өвчтөн хүлээн авах байгууллага)-ын урилгаар зорчих-----12
- В. Гадаадын өвчтөн хүлээн авах байгууллага (Эмнэлгийн болон хүлээн авах байгууллага)-ын урилгагүй зорчих-----13

## 4. Богино хугацааны бизнес (С-3-4)

- А. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч компаний ажилтан -----14
- В. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлд бүртгүүлээгүй хувиараа бизнес эрхлэгч -----15

## 5. Шилдэг аж ахуй нэгжээс урьсан богино хугацааны бизнес (С-3-6) -----16

## 6. Их дээд сургуульд суралцах (D-2) -----17

## 7. Хэлний бэлтгэл (D-4-1) -----18

## 8. Гэрлэлтээр цагаачлах (F-6) -----19

## 9. Дабль буюу хоёр удаагийн виз -----21

**10. Олон удаагийн виз -----22**

**11.Нэг удаа/Дабль буюу хоёр удаагийн виз хамт мэдүүлэгч -----27**

※Энэхүү виз мэдүүлэх журамд багтаагүй урт болон богино хугацааны виз мэдүүлэхэд бүрдүүлэх бичиг баримтыг HiKorea [www.hikorea.go.kr](http://www.hikorea.go.kr) руу орж мэдээллийн цэс-хилээр орж гарах/оршин суух заавар-виз/урилга явуулах цэсэнд дэх виз тус бүрээр бүрдүүлэх материал гэсэн хэсгээс авна уу.

**[Хавсралт] Цагаачлалын хуулийн хэрэгжих тогтоолын 12 дугаар бүлэгт заасан гадаадын иргэний оршин суух статус  
(Үйл ажиллагааны хамрах хүрээ) -----28**

## 1.Богино хугацааны нийтлэг (С-3-1) статус

o Виз олгох шалгуур : Богино хугацаагаар зорчих (С-3) ангилалын дагуу зорчигч гэдэгт аялал жуулчлал (С-3-2) шилдэг аж ахуй нэгжийн урилгаар богино хугацааны бизнес (С-3-6) ангиллаас бусад зорилгоор 90 хоног хүртэлх хугацаанд оршин суух гэж байгаа зорчигч (Ашиг олох зорилгоор зорчих нь үүнд хамаарахгүй)

### А. Хурал семинар, төрөл бүрийн арга хэмжээнд оролцогч болон нөхөрсөг тэмцээн уралдаанд оролцогч (Шагналт байранд орох үед шагналыг авах боломжтой тэмцээний оролцогч)

Д/Д	Бүрдүүлэх материал	Тайлбар
1	Визний анкет	Сүүлийн үеийн 6 сарын дотор авхуулсан 3.5 x 4.5см хэмжээтэй өнгөт цээж зураг болон визний хураамж 30 ам доллар тушаасан баримт
2	Гадаад паспорт, гадаад паспортын хуулбар 1 хувь	
3	Цагдаагийн газрын тодорхойлолт	Анх удаа виз мэдүүлэгчдэд хамааралтай (Цагдаагийн ерөнхий газраас уг тодорхойлолтыг олгоно)
4	Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын лавлагаа	Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа болон төрсний бүртгэлийн лавлагаа ( 25 нас хүрээгүй иргэд төрсний бүртгэлийн лавлагааг хавсаргана)
5	Солонгос дахь Уригч талын урилга болон арга хэмжээнд оролцохыг баталсан бичиг баримт (Эх хувь) (Урилга болон уригчийн хувийн тамганы лавлагааны эх хувийг хавсаргаж өгөх тохиолдолд урилгыг нотариатаар баталгаажуулах шаардлагагүй)	<ul style="list-style-type: none"> <li>- ЭСЯ-ны маягтыг ашиглах (Хүндэтгэх шалтгаантай тохиолдолд уригч байгууллагын маягтыг ашиглаж болох бөгөөд ЭСЯ-ны маягтын батлан даалтын агуулгыг оруулах ёстой )</li> <li>• Урилган дээр уригчийн хувийн тамгыг дарж уригчийн хувийн тамганы лавлагааны эх хувийг хавсарган өгнө</li> <li>• Байгууллага болон холбооны танилцуулга, тэмцээний тухай танилцуулга, зардал хариуцах байгууллага (Шагналын мөнгө болон оролцох зардлын талаар), оролцогчдын нэрсийн жагсаалт зэргийг хавсаргана.</li> </ul> <p><b>* Улсын байгууллага болон орон нутаг дахь төрийн байгууллагаас урьсан бол тухайн байгууллагаас олгосон албан бичгийг урилганы оронд хүлээн зөвшөөрнө</b></p>
6	Уригч талын аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар (ашгийн бус байгууллагын гэрчилгээ) болон татвар тушаасан тодорхойлолт	- Уригч тал нь улсын болон орон нутаг дахь төрийн байгууллага бол татвар тушаасан тодорхойлолт шаардлагагүй.
7	Монгол талаас оролцох байгууллагын албан хүсэлт	• Байгууллага болон холбооны танилцуулга, тэмцээний тухай танилцуулга, зардал хариуцах байгууллага, оролцогчдын нэрс зэргийг тусгаж өгнө.
8	Виз мэдүүлэгчийн эрхэлж буй ажил төрөлтэй холбоотой бичиг баримт	<ul style="list-style-type: none"> <li>➤ Бизнес эрхлэгч : Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар болон татварын албаны тодорхойлолт (тухайн харьяа дүүргийн татварын албанаас олгодог)</li> <li>➤ Ажилтан : Ажлын газрын тодорхойлолт болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарын хамт(сүүлийн 3 жилийн хугацаанд тушаасан төлөлт болон тухайн ажлын газрын ажилд авсан тушаал байх ёстой)</li> <li>➤ Оюутан : Сурч байгаа тухай тодорхойлолт</li> </ul>

## В. Сургалт, дадлага

о Виз олгох шалгуур : Засгийн газар, аж ахуйн нэгжийн зүгээс техник, технологийн нарийн мэргэжлээр дадлагажих зорилгоор виз мэдүүлж байгаа хүмүүс хамрагдана.

※ D-4 (энгийн дадлага) ангилалд багтах бөгөөд дадлагын хугацаа 90 хоногоос илүүгүй байхад хамаарна. (Амьдралын зардлаас хэтрэхгүй хэмжээний цалин авч байгаа тохиолдолд хамрагдах ба хөдөлмөрийнхөө хөлсөнд цалин авч техник, технологийн нарийн мэргэжлийг эзэмших нь үйлдвэрийн дадлага(D-3-1) ангилалд багтах тул богино хугацааны виз олгох боломжгүй.)

Д/Д	Бүрдүүлэх материал	Тайлбар
1	Визний анкет	Сүүлийн үеийн 6 сарын дотор авхуулсан 3.5 x 4.5см хэмжээтэй өнгөт цээж зураг болон визний хураамж 30 ам доллар тушаасан баримт
2	Гадаад паспорт болон гадаад паспортын хуулбар 1 хувь	
3	Цагдаагийн газрын тодорхойлолт	Анх удаа виз мэдүүлэгчдэд хамааралтай (Цагдаагийн ерөнхий газраас уг тодорхойлолтыг олгоно)
4	Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын лавлагаа	Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа болон төрсний бүртгэлийн лавлагаа ( 25 нас хүрээгүй иргэд төрсний бүртгэлийн лавлагааг хавсаргана)
5	Солонгос дахь Уригч талын урилга болон сургалтанд оролцохыг баталсан бичиг баримт (Эх хувь) (Уригчийн хувийн тамганы лавлагааны эх хувийг хавсаргаж өгвөл урилгыг нотариатаар баталгаажуулах шаардлагагүй)	- ЭСЯ-ны маягтыг ашиглах ёстой бөгөөд хүндэтгэх шалтгаантай тохиолдолд уригч байгууллагын маягтыг ашиглаж болох ч ЭСЯ-с гаргасан маягтан дахь батлан даалтын агуулгыг оруулах ёстой. • Урилган дээр уригчийн хувийн тамгыг дарж, уригчийн хувийн тамганы лавлагааны эх хувийг хавсарган өгнө. • Урилгандаа эсвэл тусад нь тухайн байгууллага болон холбооны танилцуулга, үйл ажиллагааны тухай танилцуулга, зардал хариуцах байгууллага (Онгоцны билет болон байр хоолны зардлыг даах байгууллага нь тусдаа бол тус тусад нь ангилж бичих), оролцогчдын нэрсийн жагсаалтыг хавсаргаж өгнө. <b>※ Улсын болон орон нутаг дахь төрийн байгууллага урьсан бол тухайн байгууллагаас олгосон албан бичгийг урилганы оронд хүлээн зөвшөөрнө.</b>
6	Уригч талын аж ахуйн нэгжийн гэрчилгээний лавлагааны хуулбар	
7	Уригч талын аж ахуйн нэгжийн татвар тушаасан тодорхойлолт	➢ Уригч тал нь улсын болон орон нутгийн төрийн байгууллага бол татвар тушаасан тодорхойлолт шаардлагагүй.
8	Виз мэдүүлэгчийн эрхэлж буй ажил төрөлтэй холбоотой бичиг баримт	➢ Бизнес эрхлэгч : Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар болон татвар тушаасан тодорхойлолт (тухайн харьяа дүүргийн татварын албанаас олгоно) ➢ Ажилтан : Ажлын газрын тодорхойлолт болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарын хамт(сүүлийн 3 жилийн хугацаанд тушаасан төлөлт болон тухайн ажлын газрын ажилд авсан тушаал байх ёстой) ➢ Оюутан : Сурч байгаа тухай тодорхойлолт

**С. Төрөл садныдаа зочлох (БНСУ-ын иргэн, F-2, F-5, F-6 ангиллын визтэй оршин суугч гэр бүлийн гишүүдээ урих)**

Д/Д	Бүрдүүлэх материал (Үндсэн материал)	Тайлбар
1	Визний анкет	Сүүлийн 6 сарын дотор авхуулсан 3.5 x 4.5см хэмжээтэй өнгөт цээж зураг болон визний хураамж 30 ам доллар тушаасан баримт
2	Гадаад паспорт, гадаад паспортын хуулбар 1 хувь	
3	Цагдаагийн газрын тодорхойлолт	Анх удаа виз мэдүүлэгчдэд хамааралтай (Цагдаагийн ерөнхий газраас уг тодорхойлолтыг олгоно. )
4	Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын лавлагаа	Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа болон төрсний бүртгэлийн лавлагаа ( 25 нас хүрээгүй иргэд төрсний бүртгэлийн лавлагааг хавсаргана)
5	Виз хүссэн өргөдөл	Уригч болон уригдагч ямар холбоотой болох, эрхэлж буй ажил болон аялалын зорилгыг дэлгэрэнгүй бичнэ (Тогтсон загвар байхгүй)
6	Солонгос дахь уригч талын урилга болон холбогдох бичиг баримт (Эх хувь)	<ul style="list-style-type: none"> <li>- ЭСЯ-ны маягтыг ашиглах ёстой</li> <li>➤ Уригч нь Солонгосын иргэн (үүнд Солонгосын иргэншилтэй Монгол иргэн багтана) –ий хувьд: Урилган дээр уригчийн хувийн тамгыг дарж, уригчийн хувийн тамганы лавлагааны эх хувийг хавсарган өгнө (Урилгыг нотариатаар баталгаажуулах шаардлагагүй)</li> <li>➤ Уригч нь солонгос хүнтэй гэр бүл болсон Монгол Улсын иргэний хувьд : Урилга болон солонгос нөхөр/эхнэр/-ийн урьж буйг хүлээн зөвшөөрсөн өргөдлийг (тогтсон загвар байхгүй) хавсарган өгнө (Урилгыг нотариатаар баталгаажуулах шаардлагатай )</li> <li>➤ Хуриманд оролцох тохиолдолд : Хуримын урилга болон хуримын ордонтой хийсэн гэрээний хуулбарыг нэмж хавсаргана.</li> </ul>
7	Уригчийн биеийн байцаалт	<ul style="list-style-type: none"> <li>➤ Уригчийн иргэний үнэмлэх болон гадаад паспортын хуулбар, монголын улсын харьяат эхнэр /нөхөр/-ийн гадаадын иргэний түр оршин суух үнэмлэхний хуулбар (хоёр тал)</li> <li>➤ Уригч нь Солонгос улсын иргэншилтэй Монгол иргэний хувьд нь өмнө нь гадаад иргэний бүртгэлд байсан лавлагааг (Хилийн Шалган Нэвтрүүлэх Албанаас олгоно) хавсаргана (Уг лавлагаа нь англи галигаар байгаа тухайн Монгол хүний нэрийг шалгахад шаардлагатай)</li> </ul>
8	Солонгос дахь уригчийн гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа	Монгол , Солонгос иргэдийн гэрлэснийг батлах лавлагаа (Солонгосоос олгоно)
9	Урьж буй монгол хүнтэй төрөл садан болох лавлагаа	Солонгост байгаа Монгол иргэнтэй төрөл садны лавлагаа (Монголоос олгоно)
10	Уригдаж буй монгол хүний эдийн засгийн чадварыг тодорхойлсон бичиг баримт	<p>Эцэг, эх, өвөө эмээ, үр хүүхэд гэх мэт ойрын төрөл садны хувьд эдийн засгийн чадварыг баталсан бичиг баримт хавсаргах шаардлагагүй</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Эдийн засгийн чадварыг баталсан бичиг баримт: Банкны баталгааны бичиг(3,000 ам доллараас дээш) болон хадгаламжийн дэвтрийн хуулбарын хамт(сүүлийн 3 сараас дээш хийсэн гүйлгээ)</li> <li>➤ Ажлын газрын тодорхойлолт болон нийгмийн даатгалын дэвтрийн</li> </ul>

		хуулбарын (сүүлийн 3 жилийн хугацаанд тушаасан төлөлт болон тухайн ажлын газрын ажилд авсан тушаал байх ёстой ) хамт хавсарган өгнө.
11	Солонгос дахь уригч талын эдийн засгийн чадварыг баталсан бичиг баримт (Тохирох хэсгийг сонгоно)	<p><b>Уригч тал нь компанийн ажилтан бол</b> Ажлын газрын тодорхойлолт, цалин болон татварын талаарх тодорхойлолт (хувь хүний орлогын албан татварын тодорхойлолт, өмнөх оны шимтгэлийн баримт, сар бүрийн цалингийн хэмжээг тодорхойлохын тулд сүүлийн 6 сарын цалингийн гүйлгээний хуулганаас аль нэгийг сонгон өгөх)</p> <p><b>Уригч тал нь ААН-н үйл ажиллагаа явуулагч бол</b> Аж ахуйн нэгжийн гэрчилгээний лавлагаа болон татвар тушаасан тодорхойлолт</p>

**D. Төрөл садныдаа зочлох(Бусад төрлийн ангиллаар оршин суугч урих тохиолдолд )**

Д/Д	Бүрдүүлэх материал (Үндсэн материал)	Тайлбар
1.	Визний анкет	Сүүлийн 6 сарын дотор авхуулсан 3.5*4.5 см хэмжээтэй өнгөт цээж зураг болон визний хураамж 30 ам.долларын баримт
2.	Гадаад паспорт, гадаад паспортын хуулбар-1 хувь	
3.	Цагдаагийн газрын тодорхойлолт	Анх удаа виз мэдүүлэгчдэд хамааралтай (Цагдаагийн ерөнхий газраас уг тодорхойлолтыг олгоно. )
4.	Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын лавлагаа	Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа болон төрсний бүртгэлийн лавлагаа ( 25 нас хүрээгүй иргэд төрсний бүртгэлийн лавлагааг хавсаргана)

Д/Д	Бүрдүүлэх материал (Аяллын зорилгын дагуу зайлшгүй бүрдүүлэх материал)	Тайлбар
5.	Виз хүссэн өргөдөл	Уригч болон уригдагч нарын төрөл садны холбоо болон урьсан зорилго зэргийг дэлгэрэнгүй бичих (Тогтсон загвар байхгүй)
6.	Урилга	ЭСЯ-ны маягтыг заавал ашиглах (Урилгыг нотариатаар баталгаажуулсан байх шаардлагатай)
7.	Уригчын биеийн байцаалт	Гадаадын иргэний түр оршин суух үнэмлэхний хуулбар (хоёр тал)
8.	Уригч талын ажлын газар болон санхүүгийн чадамжийг тодорхойлсон бичиг баримт	- Ажлын газрын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар, татвар тушаасан тодорхойлолт, - Солонгост суралцаж буй оюутан бол сургуулийн тодорхойлолт, дүнгийн тодорхойлолт (1 семестер болон түүнээс дээш семестер сурсан байх)
9.	Уригч тал болох уригдагчын төрөл садангийн лавлагаа	Солонгос дахь Монгол хүнтэй төрөл садан болох лавлагаа (Монголоос олгоно)
10.	Уригдаж буй хүний эдийн засгийн чадварыг батлах бичиг баримт	17-оос доош насны насанд хүрээгүй хүүхдүүд, 60- аас дээш насны эцэг, эх, эмээ, өвөө зэрэг ойрын төрөл садны хувьд санхүүгийн чадавхийг баталсан бичиг баримт шаардлагагүй ➤ Санхүүгийн чадварыг баталсан бичиг баримт: Банкны баталгааны

		<p>бичиг(3,000 ам доллараас дээш) болон хадгаламжийн дэвтрийн хуулбарын хамт (сүүлийн 3 сараас дээш хийсэн гүйлгээ)</p> <p>➤ Ажлын газрын тодорхойлолт болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарын хамт(сүүлийн 3 жилийн хугацаанд тушаасан төлөлт болон тухайн ажлын газрын ажилд авсан тушаал байх ёстой)</p>
--	--	---

- Уригч нь (Хавсралт-1) гадаад иргэдийн оршин суух зөвшөөрлийн дагуу Хамтран амьдрах (F-1), гэр бүлийн гишүүн (F-3)-ийг урих эрхтэй хүмүүс урьна. (D-3,D-4, E-8, E-9, E-10) визний ангилалтай оршин суугч нь хүн урих эрхгүй.

**Е. Монгол улсад оршин суугаа Солонгос иргэний гэр бүлийн хүн(түүний ойрын төрөл садан) Солонгост зочлох**

Д/Д	Бүрдүүлэх материал (Үндсэн материал)	Тайлбар
1.	Визний анкет	Сүүлийн 6 сарын дотор авхуулсан 3.5*4.5 см хэмжээтэй өнгөт цээж зураг болон визний хураамж 30 ам.доллар
2.	Гадаад паспорт, гадаад паспортын хуулбар-1 хувь	
3.	Цагдаагийн газрын тодорхойлолт	Анх удаа виз мэдүүлэгчдэд хамааралтай (Цагдаагийн ерөнхий газраас уг тодорхойлолтыг олгоно. )

Д/Д	Бүрдүүлэх материал (Аяллын зорилгын дагуу зайлшгүй бүрдүүлэх материал)	Тайлбар
4.	Виз хүссэн өргөдөл	Аяллын зорилгоо дэлгэрэнгүй бичих (Тогтсон загвар байхгүй)
5.	Монгол талын гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа	- Солонгос иргэний гэр бүлийн хүний ар гэрийнхэн (эцэг эх эмээ өвөө хүүхэд) Солонгос улсыг зорих тохиолдолд Солонгос иргэний гэр бүлийн хүнтэй төрөл садан болох лавлагаа ➤ Монголоос олгоно
6.	Солонгосын гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа	Солонгосоос олгоно
7.	Солонгос иргэний Монгол улсад урт хугацаагаар оршин сууж байгааг баталсан бичиг баримт	Гадаадын иргэний оршин суух үнэмлэх, Гадаадын хөрөнгө оруулагчын үнэмлэхний хуулбар зэргийг хавсарган өгнө



**Е. Солонгосын хөрөнгө оруулалттай компаний ажилтан (6 сараас дээш ажилласан байх ) Солонгост зочлох (Солонгос Захирлын хамт )**

Д/Д	Бүрдүүлэх материал (Үндсэн материал)	Тайлбар
1	Визний анкет	Сүүлийн 6 сарын дотор авхуулсан 3.5*4.5см хэмжээтэй өнгөт цээж зураг болон визний хураамж 30 ам.доллар
2	Гадаад паспорт, гадаад паспортын хуулбар-1 хувь	
3	Цагдаагийн газрын тодорхойлолт	Анх удаа виз мэдүүлэгчдэд хамааралтай (Цагдаагийн ерөнхий газраас уг тодорхойлолтыг олгоно)
4	Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын лавлагаа	Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа болон төрсний бүртгэлийн лавлагаа ( 25 нас хүрээгүй иргэд төрсний бүртгэлийн лавлагааг хавсаргана)

Д/Д	Бүрдүүлэх материал (Аяллын зорилгын дагуу зайлшгүй бүрдүүлэх материал)	Тайлбар
5.	Виз мэдүүлэгчийн ажлын газрын тодорхойлолт болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар	Солонгосын хөрөнгө оруулагтай компаний нэр болон ажилсан жил(6 сараас дээш ажилласан байх ), албан тушаал, сарын цалингийн хэмжээ зэргийг тэмдэглэсэн байх шаардлагатай Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар(сүүлийн 3 жилийн хугацаанд тушаасан төлөлт болон тухайн ажлын газрын ажилд авсан тушаал байх ёстой)
6.	Солонгосын хөрөнгө оруулалттай компаний Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар	Татварын албаны тодорхойлолтон дээрх компаний нэр адилхан байх шаардлагатай
7.	Компаний татвар тушаасан тодорхойлолт	Сүүлийн нэг сарын дотор олгогдсон байх ба компаний нэр, хаяг, утас, удирдлагын овог нэр, 2 улирлын турш татвар тушаасан байдал зэргийг тодорхойлсон байх (Татварын Ерөнхий Газраас олгоно)
8.	Гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний хуулбар	Гадаадын хөрөнгө оруулалтын газраас олгоно (Солонгосын хөрөнгө оруулалттай компаний нэр болон солонгос захирлын нэр бичигдсэн байх шаардлагатай)
9.	Солонгос захиралын буцаж ирэхийг баталсан батлан даалтын бичиг	ЭСЯ-ны маягтыг заавал ашиглах шаардлагатай
10.	Солонгос захиралын гадаад паспортын хуулбар	
11.	Солонгос захирал нь хамт явахгүй тохиолдолд Солонгосоос урилгатай байх	ЭСЯ-ны маягтыг зайлшгүй ашиглана -Урилган дээр уригчийн хувийн тамгыг дарж уригчийн хувийн тамганы лавлагааны эх хувийг хавсаргана -Хувийн тамганы лавлагааг эх хувиар өгсөн тохиолдолд урилгыг нотариатаар баталгаажуулах шаардлагагүй -Богино хугацааны (С-3-1 - С-3-4) зорилгоор явж байгаа тохиолдолд уригчийн материалыг мөн адил бүрдүүлж хавсаргах

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ( С-3-2 )

**А. Аялал жуулчлал**

Д/Д	Бүрдүүлэх материал (Үндсэн материал)	Тайлбар
1.	Визний анкет	Сүүлийн 6 сарын дотор авхуулсан 3.5*4.5 см хэмжээтэй өнгөт цээж зураг болон визний хураамж 30 ам.доллар
2.	Гадаад паспорт, гадаад паспортын хуулбар-1 хувь	
3.	Цагдаагийн газрын тодорхойлолт	Анх удаа виз мэдүүлэгчдэд хамааралтай (Цагдаагийн ерөнхий газраас уг тодорхойлолтыг олгоно)
4.	Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын лавлагаа	Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа болон төрсний бүртгэлийн лавлагаа ( 25 нас хүрээгүй иргэд төрсний бүртгэлийн лавлагааг хавсаргана)

Д/Д	Бүрдүүлэх материал (Аяллын зорилгын дагуу зайлшгүй бүрдүүлэх материал)	Тайлбар
5.	Виз мэдүүлэгчийн эдийн засгийн чадварыг баталсан бичиг баримт	<p>➤ Эдийн засгийн чадварыг баталсан бичиг баримт Жишээ нь:</p> <p><b>Ажилтан</b></p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Сарын цалин нь 1,000,000 төгрөгөөс дээш</li> <li>➤ Жилийн орлого 20,000 ам доллараас дээш эсвэл үл хөдлөх хөрөнгийн бичиг, хадгаламжийн дэвтрийн хуулбарын хамт(сүүлийн 3 сараас дээш гүйлгээ), ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарын хамт, Монголд эдийн засгийн чадвартай эсэхээ батлах бусад бичиг баримт</li> </ul> <p><b>Аж ахуйн нэгж эрхэлдэг хүний хувьд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Татвар тушаасан тодорхойлолтонд татварын хэмжээ нь 1,000,000 төгрөгөөс дээш тушаасан компаний захирал</li> <li>➤ Жилийн орлого нь 20,000 ам доллараас дээш эсвэл үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, хадгаламжийн дэвтрийн хуулбар (сүүлийн 3 сараас дээших гүйлгээ) Монголд эдийн засгийн чадвартай гэдгийг батлах бичиг баримт</li> <li>➤ Дээрх нөхцөлд хамаарах хүний хувьд эцэг, эх, хүүхэд, гэр бүлийн гишүүний хувьд дээрх хүний эдийн засгийн чадварыг батлах бичиг баримт болон төрөл садангийн лавлагааг хавсарган өгөх <ul style="list-style-type: none"> <li>✚ Дээрх шаардлагыг хангасан хүний эцэг эх, гэр бүлийн хүн болон хүүхэд нь дээрх хүний эдийн засгийн чадамжийг нотолсон бичиг баримт болон төрөл садангын лавлагааг хавсаргах шаардлагатай</li> <li>✚ Дипломат болон албан паспорт эзэмшигч, байнга визгүй зорчигч (В-2), мөн олон удаагийн визтэй бол тухайн иргэний гэр бүлийн хүн болон 17 доош насны насанд хүрээгүй хүүхэд нь холбогдох бичиг баримтаас гадна төрөл садангын лавлагааг хавсаргах</li> </ul> </li> </ul>

		шаардлагатай.
--	--	---------------

**В. Группээр аялах(Аялал жуулчлалын компаниар дамжуулах)**

Д/Д	Бүрдүүлэх материал(Үндсэн материал)	Тайлбар
1.	Визний анкет	Сүүлийн 6 сарын дотор авхуулсан 3.5*4.5 см хэмжээтэй өнгөт цээж зураг болон визний хураамж 30 ам.доллар
2.	Гадаад паспорт, гадаад паспортын хуулбар-1 хувь	
3.	Цагдаагийн газрын тодорхойлолт	Анх удаа виз мэдүүлэгчдэд хамааралтай (Цагдаагийн ерөнхий газраас уг тодорхойлолтыг олгоно. )
4.	Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын лавлагаа	Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа болон төрсний бүртгэлийн лавлагаа ( 25 нас хүрээгүй иргэд төрсний бүртгэлийн лавлагааг хавсаргана)

Д/Д	Бүрдүүлэх материал (Аяллын зорилгын дагуу зайлшгүй бүрдүүлэх материал)	Тайлбар
5.	Солонгосын аялал жуулчлалын компаний урилга	Тогтсон загвар байхгүй, хариуцагч хүний холбогдох утасны дугаарыг хавсаргах (Нотариатаар баталгаажуулах шаардлагагүй)
6.	Солонгосын аялал жуулчлалын компаний аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар болон татвар тушаасан тодорхойлолт	
7.	Монголын аялал жуулчлалын компаний аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар болон татвар тушаасан тодорхойлолт	
8.	Монгол аялал жуулчлалын компаний өмнөх аялалын группын аялалгч нар эргэн ирсэнийг батлах бичиг баримт	Аялагчийн паспортын Солонгос визтэй хэсгийг хувиалан хавсаргана.
9.	Виз мэдүүлэгчийн санхүүгийн чадамжийг баталсан бичиг баримт	Монгол талын аялал жуулчлалын компани батлан даалт хийж байгаа тохиолдолд хавсаргахгүй байж болно
10.	Хоёр талын нислэгийн захиалгын хуудасны хуулбар	Бүх аялагч нар нэг өдрийн нислэгээр ирж очих захиалга өгсөн байх шаардлагатай
11.	Аяллын хөтөлбөр	
12.	Монголын аялал жуулчлалын компаний танилцуулга	

### 3. Эмчилгээ аялал (С-3-3)

#### А. Гадаадаас өвчтөн хүлээн авах эрх бүхий эмнэлэг, байгууллагын урилгатай хүмүүс

1. Виз олгогдох хүмүүс : Гадаадаас өвчтөн хүлээн авах эрх бүхий БНСУ-ын эмнэлэг, байгууллагаас ирүүлсэн урилгын дагуу Солонгос дахь эмнэлэгт эмчлүүлэх өвчтөн болон өвчтөний асран халамжлагчаар хамт явах эхнэр, нөхөр, гэр бүлийн гишүүн
2. Уригч байгууллага : “Эрүүл мэндийн хууль”-ийн дагуу Гадаадаас өвчтөн хүлээн авах эрх бүхий эмнэлэг, байгууллагаар албан ёсоор бүртгэгдсэн байх
3. Хүсэлт гаргах : Уригч байгууллага HuNet([www.visa.go.kr](http://www.visa.go.kr)) –ээр дамжуулан виз олгох зөвшөөрөл авч гадаадын иргэнийг урих бөгөөд виз мэдүүлэгч нь уригчаас ирүүлсэн виз олгох зөвшөөрлийн хуудас(дугаар), визний анкет(зураг, визний хураамж тушаасан баримт), паспортыг ЭСЯ-нд өгнө.
4. Эмчилгээний визний төрөл
  - ◆ 90 хоногоос доош хугацаанд оршин суух тохиолдолд : 1 удаагийн (1 удаа зорчих боломжтой, хүчинтэй хугацаа 3, хураамж 30 ам доллар), Дабль буюу 2 удаагийн (2 удаа зорчих боломжтой, хүчинтэй хугацаа 6, хураамж 60 ам доллар)
  - ◆ 90 хоногоос дээш хугацаанд оршин суух тохиолдолд : G-1-10(олон удаа зорчих боломжтой, оршин суух хугацаа 1 жил хүртэл, хураамж 80 ам.доллар)

※ Энэхүү журам нь 2012.01.01-с хэрэгжиж эхлэх бөгөөд 2011.12.31 хүртэл өөрийн биеэр виз олгох зөвшөөрлийн дугаар мэдүүлэх боломжтой.

Д/Д	Бүрдүүлэх материал(Үндсэн материал)	Тайлбар
1	Визний анкет	Сүүлийн 6 сарын дотор авхуулсан 3.5х4.5см хэмжээтэй цээж зураг болон визний хураамж тушаасан баримт
2	Гадаад паспорт, гадаад паспортын хуулбар-1 хувь	
3	Виз олгох зөвшөөрөл болон зөвшөөрлийн дугаар	БНСУ-ын Гадаадын иргэн харьяатын газраас авна

#### Б. Гадаадаас өвчтөн хүлээн авах эрх бүхий эмнэлэг, байгууллагын урилгагүй хүмүүс

1. Виз олгогдох хүмүүс : Гадаадаас өвчтөн хүлээн авах эрх бүхий эмнэлэг, байгууллагын урилгагүй БНСУ дахь эмнэлэгт эмчлүүлэх өвчтөн болон өвчтөний асран халамжлагчаар зорчих гэж буй эхнэр, нөхөр, гэр бүлийн гишүүд
2. Виз мэдүүлэх : БНСУ-ын визний мэдүүлэг хүлээн авагч гурван байгууллага эсвэл долоо хоног бүрийн мягмар гаригийн үдээс өмнө ЭСЯ-ын консулын хэлтэст шууд мэдүүлэх
3. Эмчилгээний визний төрөл :
  - ◆ 90 хоногоос доош хугацаанд оршин суух тохиолдолд : 1 удаагийн (1 удаа зорчих боломжтой, хүчинтэй хугацаа 3 сар), 2 удаагийн (2 удаа зорчих боломжтой, хүчинтэй хугацаа 6 сар)
  - ◆ 90 хоногоос дээш хугацаанд оршин суух тохиолдолд : G-1-10(1 удаа зорчих боломжтой, оршин суух хугацаа 6 сар, хураамж 50 ам.доллар)

Д/Д	Бүрдүүлэх материал (Аяллын зорилгын дагуу зайлшгүй бүрдүүлэх материал)	Тайлбар
1	Визний анкет	Сүүлийн 6 сарын дотор авхуулсан 3.5х4.5см хэмжээтэй цээж зураг болон визний хураамж 30 ам доллар (дабль виз 60 ам доллар)
2	Гадаад паспорт, гадаад паспортын хуулбар-1 хувь	
	Монгол болон бусад орны эмнэлэг, сувилалын байгууллагад	➤ Монгол эмнэлгийн магадлагаа болон эмч нарын зөвлөгөөний шийдвэр

3	эмчилгээ, сувилгаа хийлгэсэн бичиг баримт	<ul style="list-style-type: none"> <li>➢ Солонгосын эмнэлэгт үзүүлэх цаг авсан захиалгын хуудас</li> <li>➢ Солонгосын эмнэлэгт эмчилгээ хийлгэж байгаа хүний хувьд цаашид үргэлжлүүлэн эмчилгээ хийлгэх шаардлагатай болохыг нотолсон эмнэлгийн магадлагаа</li> </ul>
4	Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын лавлагаа	Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа болон төрсний бүртгэлийн лавлагаа ( 25 нас хүрээгүй иргэд төрсний бүртгэлийн лавлагааг хавсаргана)
5	Өвчтөний эдийн засгийн чадварыг батлах бичиг баримт	<p>Эдийн засгийн чадварыг батлах бичиг баримт: Жишээ</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Компанийн ажилтан</li> <li>➢ Нийгмийн даатгалын дэвтэрт тэмдэглэгдсэнээр сарын цалин нь 1,000,000 төгрөгөөс дээш ажилтан</li> <li>➢ Ажлын газрын тодорхойлолт, хадгаламжийн дэвтэрийн хуулбар(сүүлийн 3 сараас дээших гүйлгээний хуулга), үл хөдлөх хөрөнгийн бичиг зэрэг Монголд эдийн засгийн чадвартай гэдгийг батлах бусад бичиг баримт <ul style="list-style-type: none"> <li>➢ Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэгч</li> </ul> </li> <li>➢ Татвар тушаасан тодорхойлолтонд татварын хэмжээ нь 1,000,000 төгрөгөөс дээш тушаасан компаний захирал</li> <li>➢ Хадгаламжийн дэвтрийн хуулбар, (сүүлийн 3 сараас дээших гүйлгээний хуулга) үл хөдлөх хөрөнгийн бичиг зэрэг Монголд эдийн засгийн чадвартай гэдгийг батлах бусад бичиг баримт</li> </ul>
6	Асран хамгаалагч хэрэгтэй тохиолдолд өвчтөн болон асран хамгалагчийн төрөл садангийн лавлагаа	<ul style="list-style-type: none"> <li>➢ Асран хамгаалагч шаардлагатай тухай эмнэлгийн магадлагаа</li> <li>➢ Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа болон төрөл садангийн лавлагаа</li> </ul>

#### 4. БИЗНЕС (С-3-4)

- **Виз олгогдох хүмүүс :** Зах зээлийн судалгаа, ажил хэргийн харилцаа тогтоох, бизнесийн зөвлөгөө, хэлэлцээ хийх, гэрээ байгуулах, хилээр орж ирэх тоног төхөөрөмж суурилуулах, засварлах, шалгах, ашиглалтыг сурах зэрэг зорилгоор богино хугацаанд зорчих иргэд

##### А. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч аж ахуйн нэгжийн удирдлага, ажилтан

Д/Д	Бүрдүүлэх материал (Үндсэн материал)	Тайлбар
1	Визний анкет	Сүүлийн 6 сарын дотор авхуулсан 3.5x4.5см хэмжээтэй цээж зураг болон визний хураамж тушаасан баримт
2	Гадаад паспорт, гадаад паспортын хуулбар 1 хувь	
3	Цагдаагийн газрын тодорхойлолт	Анх удаа виз мэдүүлэгчдэд хамааралтай (Цагдаагийн ерөнхий газраас уг тодорхойлолтыг олгоно. )
4	Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын лавлагаа	Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа болон төрсний бүртгэлийн лавлагаа ( 25 нас хүрээгүй иргэд төрсний бүртгэлийн лавлагааг хавсаргана)
5	Виз хүссэн өргөдөл	- Тухайн бизнес болон БНСУ-д зорчих болсон зорилгоо тодорхой бичнэ (тогтсон загвар байхгүй)

6	Солонгос дахь уригч талаас хүлээн авах урилга (Уригчийн хувийн тамганы лавлагааны эх хувийг хавсаргаж өгвөл урилгыг нотариатаар баталгаажуулах шаардлагагүй)	<ul style="list-style-type: none"> <li>➢ ЭСЯ-ны маягтыг ашиглах <ul style="list-style-type: none"> <li>➢ Урилган дээр уригчийн хувийн тамгыг дарж, хувийн тамганы лавлагааны эх хувийг хавсаргах</li> </ul> </li> <li>➢ Компаний захирал урих тохиолдолд Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхэлж буйг нотлох гэрчилгээний лавлагаа болон татвар тушаасан тодорхойлолт</li> <li>➢ Компанийн ажилтан урих тохиолдолд Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрхэлж буйг нотлох гэрчилгээний лавлагаа болон татвар тушаасан тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт</li> </ul> <p>Улсын болон орон нутаг дахь төрийн байгууллага урьсан бол тухайн байгууллагаас олгосон албан бичгийг урилганы оронд хүлээн зөвшөөрнө.</p>
